

# Living the LOTUS

*Buddhism in Everyday Life*



VOL. 176

Yүсгэн байгуулагчийн сургаал

## Сонсож чаддаг хүнд хүмүүс дуртай байдаг

“Нийгэмлэгийн гишүүдтэй уулзаад ярилцах үнэхээр амар шүү.” гэж хэлэх хүмүүс байдаг. Гишүүд бүгд харилцан ярилцаж буй хүнийхээ нүд рүү эгцлэн харж, үг нэг бүрийг нь толгой дохин инээмсэглэн сонсдог. Тэр нь үнэхээр сайхан санагддаг гэнэ.

Косей кай нийгэмлэгийн гишүүдийн олон сайхан зан чанарын нэгийг энэхүү дуулгавартай сонсох чадвар гэж хэлж болох юм. Ярьж буй хүн яриагаараа өөрийгөө илэрхийлж буй тул сонсож буй хүн тухайн яриаг бодитоор мэдэрч, хүлээн зөвшөөрч байгаа эсэх нь юу юунаас илүү чухал. Сонсож буй хүн ямар ч сэтгэл хөдлөлгүй байх, ийш тийшээ харах эсвэл ямар нэг илүү хөдөлгөөн хийгээд байх юм бол ярьж буй хүнд

өөрийг нь үл тоомсорлож байгаа мэт санагдаж, ярих сонирхол нь буурчихдаг.

Чин сэтгэлийн ярилцлага ч гэсэн үүнтэй адил. Яриаг удирдаж буй хүн энэ тэр зүйлд сэтгэл нь сатаарч, хөндий хоосон байдлаар хүний яриаг сонсоос ярьж буй хүнд өөрийг нь үл тоомсорлож буй мэт сэтгэгдэл төрдөг. Харин нухацтай анхааран сонсох төдийд л аврагдсан мэт сэтгэл тэнийдэг.

Чин сэтгэлийн ярилцлагаар юуны түрүүнд хүний яриаг анхааралтай сонсож сурах чухал. Мөн өөрөө хэт их ярих нь хүмүүсийн дургүйг хүргэх тохиолдол байдаг бол, харин сайн сонслоо гээд хэзээ ч хүмүүс дургүйцдэггүй.

Living the Lotus  
Vol. 176 (2020.05)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Саитоо Коичироо

**Орчуулсан:** Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## Уужуу тайван, амар амгалан

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Агуу гайхамшигт хүмүүн Ивамигийн Зэн-Тароо

Одоогийн Шиманэ мужийн Хамада хотод Чика Шигэ Зэн-Тароо хэмээх агуу гайхамшигт хүмүүн байжээ. Эдогийн он тооллын төгсгөл хавьд болсон явдал.

Агуу гайхамшигт хүмүүн гэдэг нь цагаан лянхуа цэцэгтэй зүйрлэхүйц цэвэр ариун сэтгэлтэй, сүсэг бишрэл гүнзгий буддист хүнийг хэлнэ. Бага залуудаа ааш зан тааруухан, тосгоны хүмүүст “Муу жаран хөлт Тароо” гэгддэг байсан тэрбээр удалгүй Амида бурханыг бишрэн шүтэх болж, олноо “Ивамигийн Зэн-Тароо гуай” хэмээн хүндлэгдэн хайрлагдах болсон юм.

Нэгэн өдөр Зэн-Тароо дээр төв хийдэд мөргөхөөр очиход нь гэртээ хонуулж байсан нэгэн номын нөхөр нь иржээ. Зэн-Тароо түүнийг инээмсэглэн угтгал, найз нь харин Зэн-Тароог хулгайчаар нь дуудан, хайр найргүй хараан доромжилжээ. Учир нь кимоноог нь хулгайлан авч явсан гэжээ.

Зэн-Тароо огтоос тийм зүйл хийгээгүй мөртөө “Үнэхээр муухай юм боллоо.” хэмээн хүндэтгэлтэйгээр уучлалт хүсээд, кимоногийнх нь мөнгийг төлөөд зогсохгүй “Сүйдтэй юм биш ч, энэхүү бурамтай боовыг гэрийнхэндээ өгөөрэй.” гээд бурхандаа өргөсөн бурамтай боовыг авч бэлэг болгон өгчээ.

Найз нь гэртээ хариад бүгдээрээ нөгөө боовыг идэх гэж байв. Гэтэл тэр гэрт ажилладаг охин яагаад ч юм доош харсан чигээрээ гараа ч хүргэхгүй байх нь тэр. “Яагаад идэхгүй байна вэ?” гээд асуутал охин “Зэн-Тароо гуай кимоног хулгайлсан гэж хэлсэн боловч, үнэндээ би хулгайлсан юм.” хэмээн хэргээ хүлээдэг.

Тэгэхээр, хэрэв та бүхэн Зэн-Тароо шиг байдалд орсон бол энэ явдлыг яаж хүлээж авч, хэрхэн шийдэх байсан бол?



## Бурханы зам мөрөөр аз жаргалтайгаар замнах

Дээрх явдал шиг учрыг нь олоогүй байж бусад руу дайрч давшилж, хүний яриаг сонсох ч үгүй зөвхөн амин хувиа бодогч хүнтэй ямар ч хүн аль болох учрахыг хүсэхгүй байх. Бүр хулгайд хүртэл сэрдэгдвэл тайвнаар хүлээж авч чадахгүй нь ойлгомжтой.

Тэр утгаараа Зэн-Тароогийн үйлдэл туйлын сонирхол татаж байна. Тэгвэл Зэн-Тароо үнэн учрыг тайлбарлалгүйгээр хэрэг явдлыг яагаад хүлээн зөвшөөрсөн юм бол?

Миний хувьд “Амида бурханд бүгдийг даатгадаг.” гэсэн түүний хатуу “Итгэл үнэмшил”-тэй холбоотой болов уу гэж бодож байна. “Бухимдах зүйл юу ч алга. Бурхан бүгдийг нь харж байгаа.” Тийм уужуу тайван сэтгэлтэй байж л тэрчлэн хүлээн авч чадах болов уу.

“Хэлж байгаа нь ч, хэлүүлж байгаа нь ч хоёулаа адилхан.” гэж нэгэн дуунд гардаг. Бурханы өмнө бүгд адил эрх тэгш учраас хоёрын хооронд өөрийгөө зөвтгөж, нөгөө хүнийг буруушаах нь нэг их сайхан зүйл биш гэж бодсон ч байж болох юм.

Цагаан Лянхуа Судрын “Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх бүлэг”-т “Өөрийн амь биеийг үл хайрлан зөвхөн дээргүй зам мөрийг эрхэмлэнэ.” гэсэн үг бий. Энэ бол сүсэгтэн олны үзэл санааг тод харуулсан бадаг ба зөвхөн амь нас хайран гэсэн утга төдий бус юм. Одоо энэ ертөнцөд төрж, амьдарч буй нь ямар гайхамшигтай зүйл болохыг анзаарах юм бол “Өөрөө л болж байвал болоо.” гэж зөвхөн өөрийгөө чухалчлан бодох бус, бие биеийнхээ ач тус, дэмжлэгийн хүчинд уулзан учрах тавилантайдаа талархаж явах нь маш чухал гэсэн утгаар ойлгож болох юм.

“Зөвхөн дээргүй зам мөрийг эрхэмлэнэ.” гэдэг нь тэр мэт зүйлд талархах ёстойгоо сайтар ухааран мэдэж, аль болох олон хүнтэй талархсан сэтгэлээ хуваалцахыг хэлнэ. Цагаан Лянхуа Судрын сургаалын ачаар юунд талархахаа анзаарч мэдсэн бол тэрхүү сургаалыг бусаддаа түгээж, амьдрахын баяр баясгалан хийгээд талархах сэтгэлийг хамтдаа мэдрэхийн төлөө нэг алхам урагшлах хэрэгтэй.

Гэхдээ тэр нь нөгөө хүнээ өөрчлөх эсвэл сургаалаар мунхруулах гэсэн зүйл биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Баяр хөөртэйгөөр бурханы сургаалыг хэрэгжүүлж, хүмүүстэй сэтгэлийн их баяр баясагалантайгаар харилцаж, улмаар нэг ч гэсэн хүн одоо энэ ертөнцөд амьдарч байгаадаа талархах сэтгэлтэй болох нь чухал.

Дээр гарсан Зэн-Тароогийн тухай яриаг “Бурамтай боовны тухай сургаал” гэдэг. Охины сэтгэлийг ойлгосон агуу гайхамшигт хүмүүний дулаан сайхан сэтгэлээс уужуу тайван, амар амгалан байх сүсэгтэн хүний мөн чанарыг харж болно.

«Косей» 2020 оны 5 дугаар сарын дугаар



# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## «Оройн Дээд Цагаан Лянхуа Судар»

Газар доороос гарсныг өгүүлэх

15 дугаар бүлэг

Дөнгөж энэ бүлгээс Бурхан гэж юу болох нь тодорхой болдог “Үндсэн үүд” хэсэг эхэлдэг. Эхэн хагас нь үндсэн үүд хэсгийн өмнөтгөл ба үлдсэн хагасаас “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх 16 дугаар бүлэг” бүхэлдээ, түүний дараахь “Эрдэм буяныг ялган өгүүлэх 17 дугаар бүлэг”-ийн эхэн хагас хүртэлх “Нэг бүлэг, хоёр хагас хэсэг” нь гол хэсэг болно.

### Бусад бодисадва нарын андгай тангараг

Ингээд Шагжамүни бурхан “Амар амгалан явахуйг өгүүлэх 14 дүгээр бүлэг”-ийн сургаалыг айлдаж дуусахад, өөр улсуудаас ирсэн хэмжээлшгүй тоотон бодисатва нар босон “Хэрэв та болгоовоос бид бүхэн ч бас энэхүү замбуутивд үлдэж, ертөнц мөхсөний хойно ч сургаалыг тань сахин хамгаалж, түгээн дэлгэрүүлмээр байна. Болохсон болов уу.” хэмээн хүсдэг.

Шагжамүни бурхан “Та бүхний хүсэлд талархлаа. Энэ замбуутивд эдгээр хязгааргүй олон тоотон бодисадва үргэлжид эртнээс оршиж, Цагаан Лянхуа судрын сургаалыг түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн тул тэгэх хэрэг үгүй болно.” хэмээн хариулдаг.

### Газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нар тодорсон нь

Тэр мөчид эх газар дээр хязгааргүй олон тоотон ан цав үүсч, тэндээс Бурхан багшаас өөрцгүй эрхэмсэг дүр төрхтэй тоолж баршгүй олон бодисадва хөөрөн гарч иржээ. Эдгээр бодисатва нарын дотор удирдагч багш нар болох Дээд Явдалт, Хязгаалшгүй Явдалт, Ариун Явдалт, Түвшин Явдалт хэмээх дөрвөн бодисадва Шагжамүни бурханы өмнө гарч ирээд мэндэлсэнд Шагжамүни бурхан машид дотноор тэдэнтэй мэндэлнэ.

### Майдар бодисадвагийн эргэлзээ

Уг байдлыг бишрэн харж байсан Майдар бодисадвагаас эхлээд замбуутивийн бодисадва нар “Ийм агуу бодисадва нар ингэхэд хаанаас ирсэн, ямар учиртай хүмүүс вэ” хэмээн эргэлзэн бодов. Тэгээд Майдар бодисатва учрыг

Шагжамүни бурханаас асуухад, “Их газраас хөөрөн гарч ирсэн эдгээр олон бодисадва нар бол миний замбуутивд гэгээрснээс хойш номын мөрд оруулсан шавь нар бөгөөд өнөөг хүртэл замбуутивийн доорх огторгуйд байсан билээ. Тийнхүү эдгээр бодисадва нарыг өнө эртнээс би номын мөрд оруулсан билээ.” хэмээн хариулдаг.

Ингээд улам ойлгомжгүй болоод ирлээ. Шагжамүни бурхан гэгээрлийг олсноос хойш дөнгөж 40-өөд жил болсон байтал хязгааргүй олон тоотон эдгээр хүмүүсийг, бүр тэгээд бурхантай дүйцэхүйц агуу бодисадва болгон заан сургасан гээд бодохоор яасан ч санаанд багтамгүй. Түүнчлэн бурхан багшийн дэргэд урт удаан хугацаанд бараа болж байсан атал эдгээр хүмүүсийг огтхон ч харж байсан удаа үгүй билээ.

Гэтэл сая “Үнэндээ бол өнө эртнээс номын мөрд оруулсаар ирсэн.” гэсэн болохоор үнэхээр





толгой эргэж гүйцэх нь. Юу болоод байгааг ойлгохгүй болсон Майдар бодисадва шууд түүнийгээ хэлээд, учрыг айлдахыг хүссэнээр уг бүлэг дуусдаг.

### Өнө мөнхийн бодисатва ба ертөнцөд заларсан бодисадва

Энд Өнө мөнхийн ба ертөнцөд заларсан бодисадвагийн тухай тайлбарлах хэрэгтэй болов уу.

Ертөнцөд заларсан бодисадва гэдэг нь хүн болж төрсөн Шагжамүни буддагийн ачаар номын мөрд орсон бодисадваг хэлнэ. Хүн болж төрсөн Шагжамүни будда гэдэг нь Энэтхэгт төрж, бодь модны доор суун гэгээрлийг олсон Шагжамүни бурханыг хэлдэг. Тиймээс ертөнцөд заларсан бодисадва гэдэг нь энэ ертөнцөд төрөхөөр заяагдсан хүн хэмээх юм.

Өнө мөнхийн бодисадва гэдэг нь Язгуурын Бурханы ачаар номын мөрд орсон бодисадваг хэлнэ. Язгуурын Бурхан гэдэг нь мэдээжийн хэрэг цаашид гарах “Түүнчлэн Ирсэний тухай өгүүлэх бүлэг”-т гарах Ялж төгс нөгчсөн бурханыг хэлнэ. Язгуурын буддагийн ачаар номын мөрд орсон өнө мөнхийн бодисадва гэдэг нь газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нар юм. Тиймээс хэмээжээлшгүй тоот настай Ялж төгс нөгчсөн бурханы талаар хараахан ойлгоогүй байгаа Майдар бодисадва нар нь Шагжамүни бурханы хэлснийг сайн ойлгоогүй байна.

Энэ мэтчилэн өнө мөнхийн бодисадва, ертөнцөд заларсан бодисатва хоёрын ялгаа тов тодорхой байх бөгөөд өнө мөнхийн бодисадва болох Дээд явдалт гэх мэт дөрвөн бодисатва нараас эхлээд газар доороос хөөрөн гарч ирсэн бодисатва нар хичнээн гайхамшигтай бодисадва болохыг энд амаа олохгүй магтсан.

Яагаад Өнө мөнхийн бодисадвагийн ямар агуу болохыг онцолсон бэ хэмээвээс, “Өнө мөнхийн бодисадва болохоо ухамсарласан хүн хичнээн гайхамшигтай оршихуй болохыг сайн ойлгуулахыг хүссэн учраас тэр билээ. Бүх хүнийг “Газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нар мэт гайхамшигт оршихуй болох юмсан.” гэсэн хүсэл мөрөөдөлтэй байгаасай хэмээн хүссэнээс өөрцгүй. Тиймээс л энд онцлон сануулсан юм.

Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан өөрөө энэ ертөнцөд мэндэлсэн Ялж төгс нөгчсөн Язгуурын Бурхан билээ. Шагжамүни бурханы жинхэнэ Ялж төгс нөгчсөн Язгуурын Бурхан болохыг мэдэж өөрөө түүний жинхэнэ хүүхэд нь болохоо зүрх сэтгэлийнхээ гүнээс ухаарч, Язгуурын Бурханы хувиар айлдсан энэхүү

Цагаан Лянхуа Судрын сургаалыг хэрэгжүүлсэн хэн боловч хэдийнээ жинхэнэ хүн хийгээд өнө мөнхийн бодисадва мөн болно.

Энэ утгаараа бодит ертөнцөд төрсөн бодисадва ба өнө мөнхийн бодисадва гэдэг нь угтаа нэг л зүйлийг хэлж байгаа юм. Энэ талаар дараагийн “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх бүлэг”-т тодорхой өгүүлэх болно.

Өнөөгийн бид ч гэсэн Шагжамүни бурханы сургаалыг сурч, хэрэгжүүлэн, чадлынхаа хирээр энэ хорвоогийн хүмүүсийг авран нигүүлсэх төдийд “Ертөнцөд заларсан бодисадва” болох болно. Хэрэв “Өөрийгөө Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Бурханы ачаар номын мөрд орсон, газар доороос гарч ирсэн бодисадва ба Язгуурын Бурхантай нэгэн бүхэл.” гэдгээ сэтгэлийнхээ угаас мэдэрч, Язгуурын Бурханы туйлын хүсэл зорилгыг өөрийнхөө туйлын хүсэл зорилго хэмээн ойлгож, Цагаан Лянхуа Судрын үзэл санааны дагуу бодисадвагийн үйл хэргийг хэрэгжүүлбээс гаднаасаа харагдах байдал нь ялгаагүй боловч гайхамшигтай өнө мөнхийн бодисадва” болох болно. Өнө мөнхийн бодисадва ба Ертөнцөд заларсан бодисатва нарыг гаднаас нь харахад адилхан сүсэг бишрэлтэй юм шиг боловч тэрхүү сүсэг бишрэлийн агуулгыг нь аваад үзэх юм бол асар том ялгаа байдаг. Тэр нь сургаал айлдах болон хүмүүсийг аврах байдалд илэрдэг учиртай.

### Газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нарын үнэ цэнэ

Уг бүлэгт гэнэт гарч ирдэг “Газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва” нарын тухай янз бүрээр тайлбарласан байдаг. Ялангуяа дараах гурван зүйл хамгийн чухал нь гэж бодож байна.

Нэгдүгээрт, Шагжамүни бурхан бусад ертөнцөөс ирсэн бодисадва нарын хүсэлтээс татгалзаж, газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нарт энэ замбуутивийн хүмүүсийг номын зам мөрд оруулахыг даалгадаг.

Өөрөөр хэлбэл “Аль ч ертөнц байсан тэнд амьдарч буй хүмүүсийн өөрсдийнх нь хичээл зүтгэлийн үрээр тухайн ертөнцөд энх тайван тогтож, өөрийн гараар аз жаргалтай сайхан амьдралыг цогцлоож явах ёстой.” гэсэн сургаал юм.

Хоёрдугаарт, замбуутивийн доорх огторгуйд амьдарч, гэгээрлийн замд хүрэхийг тэсэн ядан хүлээж байсан бодисадва нар нь Шагжамүни бурханы дуу хоолойг сонсоод, их газраас хөөрөн гарч ирсэн гэсэн үг.

“Замбуутивийн доорх огторгуй”-д амьдрагч бодисадва гэдэг бол яах аргагүй энэ ертөнцийн хүн бөгөөд “Хоосны сургаал”-ыг гэгээрч, амар



амгалан орших боловч түүнийгээ хүний ертөнцийг аврахын төлөө зориулдаггүй хүн юм. “Хоосны сургаал”-ыг гэгээрэх гэдгийг хүнээр төсөөлөөд хэлэх юм бол “Хүний мөн чанар гэдэг нь эрх тэгш бурханлаг чанарт оршино.” гэдгийг хэлнэ. Үнэхээр үүнийг гэгээрсэн ч дотроо л сэтгэл ханах төдийгөөр түүнийгээ ямар нэг зүйлийн төлөө зориулдаггүй хүн юм. Тийм байх юм бол тухайн хүн өөрөө хар муу санаагүй, мундаг хүн байлаа ч нийгмийг аврах үүрэг хариуцлагад бол нийцэхгүй.

Яасан ч гэсэн нэг удаа энэ ертөнцийг үзэж туулах ёстой. Өөрөөр хэлбэл бодит нийгмийн амьдралыг үзэж туулж, муу муухай хийгээд бүрхэг манан дунд төөрөлдсөн олон дунд орж, зовлон зүдгүүртэй нь нүүр тулах шаардлагатай. Тэгж байж л жинхэнэ хүнийг удирдан залж, аварч чадах учиртай. Өөрөөр хэлбэл хэт бодит бусаар сэтгэх нь оновчгүй бөгөөд бодит байдалтайгаа уялдахгүйгээр үр дүнтэйгээр хүнийг аврах аргагүй гэсэн үг.

Гуравдугаарт, тэдгээр газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва нарын удирдагч дөрвөн багш бодисатва нарын нэрэнд Дээд явдалт, Хязгаалшгүй Явдалт, Ариун Явдалт, Түвшин Явдалт хэмээн бүгдэд нь “явдалт” гэсэн үг орсон байгаа.

Цагаан Лянхуа Судрын эхэн хагаст голчлон онолын сургаалаар эрдэм мэдлэгийг сургасан байдаг бол төгсгөлд нь эдгээр “Явдалт” бодисадва хязгааргүй тоогоор гарч ирдэг нь гарцаагүй сургаалыг хэрэгжүүлж, биелүүлэх

ёстой гэсэн утгатайгаас өөрцгүй билээ. Эхний хагаст гардаг Бодит үүдийн сургаалаар айлдсан “Хамаг юмсын жинхэнэ дүр төрх”-ийг олж харах билиг оюуныг бодит амьдрал дээр илэрхийлсэн ба нигүүлсэхүйн үйлийг хэрэгжүүлэгч хүн л жинхэнэ бодисадва бөгөөд жинхэнэ бурхан багшийн сургаалыг энэ ертөнцөд дэлгэрүүлэгч хүн юм. Энэ бол өнөөгийн ертөнцийн бидэнд ч тэр чигээрээ хамааралтай зүйл тул сайтар ухан ойлгох ёстой зүйл гэж бодож байна.



## Бурханы зам мөрөөр аз жаргалтайгаар замнах

Шинэ төрлийн корона вирусын уршгаар сэтгэл тайван сууж чадахгүй өдрүүд үргэлжилсээр байна. Гишүүд та бүхнийгээ эрүүл энх байгаасай хэмээн хүсэн залбирч байна.

Энэ сарын ерөнхийлөгчийн айлдвар “Уужуу тайван, амар амгалан байх” гэсэн сургаал байсан. Эрх чөлөөгүй энэ үед хэрхэн бурханы зам мөрөөр замнах вэ гэдгийг заан сургасан. Эдогийн үеийн агуу гайхамшигт хүмүүн Зэн-Тароо шиг хулгайч гэж хэлүүлсэн ч, өөрийгөө өмөөрөхгүй, бүхнийг Бурханд даатгаж чадах хатуу итгэл үнэмшилтэй байх аваас өдөр бүрийг уужуу тайван, амар амгалан өнгөрүүлж чадна хэмээжээ.


Мөн судрын 13-р бүлгийн “Амь биеэ үл хайрлан, гагцхүү дээргүй зам мөрийг эрхэмлэнэ” хэмээх хэсгийг иш татан, энэ бөмбөрцөг дээр олон зүйлийн ач тусаар амьдарч байгаадаа талархах чухал бөгөөд амь насыг хүртсэндээ талархах сэтгэлтэй хүн нэгээр ч гэсэн нэмэгдэх болтугай хэмээн сургаал номыг түгээж амьдрах нь бурханы зам мөрөөр баяр баясгалантай алхах явдал юм хэмээн заан сургасан байна.

Энэ сар тийнхүү сэтгэлээр сургаал дэлгэрүүлэх зам мөрд хичээцгээе.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Сайтоо Коичи



# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
 Email: [info@rkhawaii.org](mailto:info@rkhawaii.org) URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
 POBox 33636, CA 90033, USA  
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
 Email: [rk-la@sbcglobal.net](mailto:rk-la@sbcglobal.net) URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
 POBox 778, Pacifica, CA 94044, USA  
 TEL: 1-650-359-6951 Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org)  
 URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
 TEL: 1-212-867-5677 Email: [rkny39@gmail.com](mailto:rkny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
 TEL: 1-773-842-5654  
 Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
 Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA  
 TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
 URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437  
 Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org) URL: <http://www.rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA  
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745  
 Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261  
 Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
 URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
 Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>



Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

### Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

### 在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

### 在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

### 社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

### 台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

### Risho Kosei-kai South Asia Division

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

### Risho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

### Risho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

### Risho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,  
Bihar, India

### Risho Kosei-kai of Patna Dharma Center

### Risho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

### Risho Kosei-kai of Singapore

### Risho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

### RKISA Risho Kosei-kai International of South Asia

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Bangkok

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairisho@gmail.com

### Risho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

### Risho Kosei-kai of Polonnaruwa

### Risho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL/FAX: 880-31-626575

### Risho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

### Risho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

### Risho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

### Risho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

### Risho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

### Risho Kosei-kai Friends in Shanghai

### Risho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia  
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

### Risho Kosei-kai of Erdenet

### Risho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

### Risho Kosei-kai of the UK

### Risho Kosei-kai of Paris

### Risho Kosei-kai of Venezia

### Risho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibe-rk.org>